

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.01.04

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтод тусгагдсан цагдаагийн ажил, үйлчилгээ, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг ба тайлант хугацаанд Салбар зөвлөлийн дарга, гишүүн 2, нарийн бичгийн дарга нар албанаас чөлөөлөгдөн өөр албан тушаалд шилжиж, шинээр алба хаагчид томилогдсонтой холбогдуулан Салбар зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, томилуулах саналыг танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 465, 466, 467 дугаар тогтоолоор 4 гишүүнийг чөлөөлж, 3 гишүүнийг шинээр томилсон.

Төрийн албаны шинэтгэлийн бодлого, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн 2023 оны зорилтыг хэрэгжүүлэх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр хангах, албаны сургалт, хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх, алба хаагчийн ёс зүйг дээшлүүлж, сахилга, хариуцлага, хандлагыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, баталгаагаар хангах, салбар зөвлөлийн дотоод зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааг 3 бүлэг, 22 арга хэмжээтэйгээр төлөвлөн, хэрэгжилтийг 100 хувь ханган, дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, Салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, алба хаагчид цэргийн дээд цол олгох асуудал болон Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын холбогдох ангилалд адилтган авч үзэх жагсаалт болон удирдах, гүйцэтгэх ажилтны сул 3 орон тоонд тусгай шалгалт зохион байгуулсан дүнг тус тус хэлэлцэн баталгаажуулсан.

Мөн төрийн албаны томилгооны зөрчлийг арилгах, албан тушаалын тодорхойлолтод заасан мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагын шаардлагыг хангасан алба хаагчийг сонгон томилох зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2021 оны “Хуралдааны дэг” 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Салбар зөвлөлийн дүгнэлтийн хуудас”-ыг ашиглан салбар зөвлөлийн хурлыг хялбаршуулсан байдлаар явуулж, удирдах албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсэн 138 алба хаагчийн, мэдээлэл, тухайн албан тушаалд тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэх талаар салбар зөвлөлийн гишүүдэд танилцуулж, дүгнэлт гаргуулан, томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлж хэвшсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтны

мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд бүрэн бүртгэж, цалинг “Цалингийн нэгдсэн систем”-ээр бодон олгож байна.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолтуудыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-д нийцүүлэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/233 дугаар тушаалаар 151, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны Б/16 дугаар тогтоолоор 51, нийт 5 нэгжийн 202 албан тушаалын тодорхойлолтыг баталж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/308 дугаар “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалаар мэргэжлийн зэргийн индексэд өөрчлөлт орсонтой холбогдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 443 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/401 дүгээр тушаалаар батлуулсан.

Монгол Улсын хуулийн төсөлд санал өгөх, боловсруулах чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн тайлан гаргах 4, холбогдох хууль тогтоомжийн 13 төслийг боловсруулж, Засгийн газрын тогтоол, эрх зүйн актын 75 төсөлд тусгах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн акт шинэчлэн баталсан, нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 48, бусад 6 дүрэм, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох саналыг авч, нэгтгэн боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ажлын байрны шаардлага хангаж, мэргэшлийн шалгалтад тэнцэж томилогдсон алба хаагчидтай “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад алба хаах гэрээ”-г байгуулснаар байгууллага, алба хаагчдын эрх ашгийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах, тогтвор суурьшилтай ажиллахад чухал нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын хууль 8, Монгол Улсын Их Хурлын тогтоол 5, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 7, Ерөнхийлөгчийн зарлиг 6, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл 3, Засгийн газрын тогтоол 19, Ерөнхий сайдын захирамж 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 22, Засгийн газрын албан даалгавар 3, нийт 76 шийдвэрийн 171 зүйл, заалтын хэрэгжилтийг хангаж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/721 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор баталсан “Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөлтэй танилцаж, дэмжих боломжгүй тухай саналыг 2023 оны 01/34 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.”, 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан, цагдаагийн алба хаагч

бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цагдаагийн цолтойгоор ажилласан, цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан болон хуульд заасан бусад хугацааг цагдаагийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцно.” гэж зохицуулсныг хэрхэн нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, байгууллага хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг хангах талаар тодруулга санал, зөвлөмжийг боловсруулж, 2023 оны 01/58, 01/118 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Дотоодын цэргийн чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцаа, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар батлуулах ажлыг зохион байгуулсан.

Тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт заасны дагуу “Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилт олгох журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар 2023 оны 01/189 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хоёр.Төрийн албаны нөөц бүрдүүлэх төрийн албаны шалгалт зохион байгуулах чиглэлээр

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2023 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэхээр нийт 1544 алба хаагчийн санал, материал ирүүлснийг нэгтгэж, шалгуур, шаардлага хангасан эсэхийг нэг бүрчлэн тулгаж, шаардлага хангасан 1437 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, мэргэшүүлэх багц сургалтад хамруулахаар Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд хүргүүлж, шалгалтад тэнцсэн алба хаагчдаас Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны Б/03 дугаар тогтоолоор ахлагчаас офицер албан тушаалд 253, ахлах албан тушаалд 597, чиглэлийн ахлах, тасаг, хэсгийн даргын албан тушаалд 294, алба, газар, хэлтсийн даргын албан тушаалд 133, нийт 1277 алба хаагчийг нөөцийн жагсаалтад бүртгэсэн.

Мөн хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр шаардлага хангасан ахлагч бүрэлдэхүүнийг офицер албан тушаалд дэвшүүлэн томилуулах нөөцийн жагсаалтад бүртгэх ажлыг зохион байгуулж, 182 алба хаагчийг нөөцөд бүртгэсэн

2023 онд албан тушаал шатлан дэвшүүлэх нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн 1459 алба хаагчаас 563 буюу 38.6 хувь нь албан тушаал дэвшин томилогдсон.

Нөөцийн жагсаалт хүчинтэй буюу 2021-2023 оны нөөцөд бүртгэлтэй алба хаагчдын томилолтын байдлыг нэг бүрчлэн хөтөлж, 2021 оны нөөцийн жагсаалтад 272, 2022 оны нөөцийн жагсаалтад 396, 2023 оны нөөцийн жагсаалтад 896 алба хаагч бүртгэлтэй байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтран мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг 8 удаа зохион байгуулсан.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтарсан “Цагдаа”, “Цагдаа жолооч”, “Харуулчин” мэргэжлээр элсэн суралцах иргэдийг сонгон шалгаруулах шалгалтыг 8 удаа зохион байгуулж, шалгалтад орох хүсэлт гаргасан 2152 иргэнээс шалгалт авч, 1505 иргэнийг нөөцөд бүртгэн, мэргэжил олгох

сургалтад хамруулж, 1011 иргэнийг сул орон тоонд томилон, одоогоор 215 иргэнийг суралцуулж байна.

Тайлант онд цагдаагийн байгууллагад анх орох иргэний 2020, 2021, 2022, 2023 оны нөөцөд бүртгэлтэй 1126, цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургууль төгссөн 270, нийт 1396 иргэн, алба хаагчийг сул орон тоонд томилсон.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 8.1, 8.2 дахь заалтыг үндэслэн Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газрын дарга, Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Орхон аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн Хамгаалалтын нэгдүгээр тасгийн даргын албан тушаалын сул орон тоог дотоодоосоо нөхөх зорилгоор тусгай шалгалтыг 2023 оны 10 дугаар сарын 16-20, 11 дүгээр сарын 22-30, 12 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газрын даргын сул орон тоонд 1, Орхон аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн Хамгаалалтын нэгдүгээр тасгийн даргын албан тушаалын сул орон тоонд 2, нийт 3 алба хаагч оролцож, шалгалтын дүнг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, албан тушаал бүрд хамгийн өндөр оноо авсан алба хаагчийг томилуулах саналыг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, шалгалтын дүнг үндэслэн томилолтын асуудлыг шийдвэрлэсэн.

Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргын сул орон тоонд өрсөлдөх алба хаагчийн материал ирээгүй тул албан тушаалын тодорхойлолтын ерөнхий болон тусгай шаардлага хангасан алба хаагчийг томилуулахаар судалж байна.

Гурав. Алба хаагчийн ёс зүйг дээшлүүлж, төрийн албан дахь сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас энэ оны жилийн эцсийн байдлаар 905 сахилгын зөрчилд 1011 алба хаагч холбогдсон нь урд оны мөн үетэй харьцуулбал сахилгын зөрчил 298 нэгжээр буюу 24.8 хувь, алба хаагч 306 нэгжээр буюу 23.2 хувиар тус тус буурсан.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 676 буюу 66.9 хувийг офицер, 331 буюу 32.7 хувийг ахлагч бүрэлдэхүүн, 4 буюу 0.4 хувийг энгийн ажилтан эзэлж байна.

Нийт сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 955 буюу 94.5 хувь нь эрэгтэй, 56 буюу 5.5 хувь нь эмэгтэй алба хаагч байна.

Нийт сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 155 буюу 17.1 хувь нь удирдах албан тушаалтан сахилгын зөрчил гаргаж, сахилгын шийтгэл оногдуулсан. Үүнд:

- Алба, албаны дэд, газрын дарга, ангийн захирагч - 12 буюу 1.3 хувь,
- Хэлтсийн дарга, ангийн захирагчийн орлогч, тусгай салбарын захирагч 37 буюу 4.1 хувь,
- Тасаг, хэсгийн дарга албан тушаалтан 106 буюу 11.7 хувь, Удирдах албан тушаалтнаас үйлдсэн сахилгын зөрчил урд оны мөн үеэс 30.8 хувиар буурсан байна.

Нийт сахилгын зөрчлийн 449 буюу 49.6 хувийг орон нутагт, 291 буюу 32.2

хувийг нийслэл хотод, 22 буюу 2.4 хувийг харьяа нэгж, 112 буюу 12.4 хувийг албад, 3 буюу 0.3 хувийг Төв байрны нэгж, 28 буюу 3.1 хувийг Дотоодын цэргийн алба хаагчдаас үйлдсэн байна.

Анги, байгууллагуудаас Архангай, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Ховд аймаг, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар, Төв архив зэрэг байгууллагын алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зөрчил урд оны мөн үеэс 5.5-100 хувь өсөж, бусад анги, байгууллагуудын дүн буурсан болон адил түвшинд байна.

Нийт зөрчлийн 437 буюу 48.3 хувь нь ажлын хариуцлага алдсан, 106 буюу 11.7 хувь нь ажил тасалсан, 232 буюу 25.6 хувь нь архидан согтуурсан, 70 буюу 7.7 хувь нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн байна. Мөн 37 буюу 4.1 хувь нь үүрэг даалгавар үл биелүүлсэн, 9 буюу 0.9 хувь нь төсвийн хөрөнгийг ашигласан, үрэгдүүлсэн, зориулалтын бус зарцуулсан төсвийн хөрөнгийг ашигласан, үрэгдүүлсэн, зориулалтын бус зарцуулсан, 17 буюу 1.9 хувийг хахууль, шан харамж авсан, өгсөн, бусдад давуу байдал бий болгосон, бусдын үйл ажиллагаанд хөндлөгөөс хууль бусаар нөлөөлсөн, 117 буюу 12.9 хувь нь цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн, 254 буюу 28.1 хувь нь цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн, 7 буюу 0.8 хувь нь Цэргийн сахилгын дүрэм зөрчсөн, 46 буюу 5.1 хувь нь Дотоодын цэргийн ёс зүйн дүрэм зөрчсөн, 113 буюу 12.5 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой 3486 өргөдөл, гомдол хүлээн авч, 3805 алба хаагчид холбогдуулан шалгасны 3111 буюу 81.8 хувийг офицер, 687 буюу 18.1 хувийг ахлагч, 7 буюу 0.1 хувийг энгийн ажилтан тус тус эзэлж байна.

Урд оны мөн үеийн дүнтэй харьцуулбал өргөдөл, гомдол 548 буюу 18.7 хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 560 буюу 17.3 хувиар тус тус өссөн байна.

Нийт өргөдөл, гомдлын 110 буюу 3.2 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 299 буюу 8.6 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 3026 буюу 86.8 хувьд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 16 буюу 0.5 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах хугацаа өнгөрсөн үндэслэлээр хааж шийдвэрлэсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас үйлдсэн сахилгын зөрчил урд оны мөн үеэс 298 нэгжээр буюу 24.8 хувь, алба хаагч 306 нэгжээр буюу 23.2 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Сахилгын зөрчлийн хэлбэрээр авч үзвэл ажлын хариуцлага алдсан зөрчил урд оны мөн үеэс 76 нэгжээр буюу 14.8 хувь, архидан согтуурах зөрчил 42 нэгжээр буюу 15.3 хувь, ажил тасалсан зөрчил 13 нэгжээр буюу 10.9 хувь, ЭХХШТХ зөрчсөн зөрчил 45 нэгжээр буюу 39.1 хувиар тус тус буурсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 3486 өргөдөл, гомдол /үүнээс 126 тусгай дугаарын утсаар 850/ хүлээн авч, гэмт хэргийн шинжтэй 110 өргөдлийг харьяаллын дагуу шилжүүлж, шалгалтын дүнд 299 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, нийт өргөдөл, гомдлын 3026 буюу 86.8 хувийг алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй буюу нотлогдоогүй үндэслэлээр шийдвэрлэсэн.

Урд оны мөн үеэс өргөдөл, гомдол 548 нэгжээр буюу 18.7 хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 560 нэгжээр буюу 17.3 хувиар тус тус өссөн нь улс төр, нийгмийн байдал, шалгах ажиллагаа хийгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн тоо,

цахим болон хэвлэл мэдээллийн нөхцөл байдал, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлийг хангах чадавх, мэргэших байдал, удирдах, ахлах албан тугшаалтнуудын хяналт, зохион байгуулалт, хүртээмж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна гэж үзэж байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид ирүүлсэн өргөдөл гомдлоос 789 /нийт өргөдлийн буюу 22.6 хувь/ өргөдөл, гомдол нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүйтэй холбоотой, 801 буюу 22.97 хувь нь хэрэг маргаан дутуу шалгасан, хэргийн хугацаа хэтрүүлсэн, 550 буюу 15.8 хувь нь ЭБШХ болон бусад хууль дүрэм зөрчсөнтэй холбоотой буюу нийт өргөдөл, гомдлын 38.8 хувь нь мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой гомдол эзэлж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2023 оны сургалт, зөвлөгөөний хүрээнд сахилгын зөвлөгөөнийг “Сэтгэл зүйд суурилсан манлайлал” сэдэвт хэлэлцүүлгийн хэлбэрээр зохион байгуулж, хэлэлцүүлэгт 8 анги, байгууллагын удирдах ажилтнууд илтгэл мэдээлэл хийсэн.

Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулж, гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны нэгдүгээр улирлын Сахилга, ёс зүй, хариуцлагын өргөтгөсөн зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 06-ны өдөр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 100 байршлаас 922 алба хаагч оролцлоо.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сахилгын зөрчлийг бууруулах зорилгоор “Гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилгүй хамт олон болохын төлөө” болзолт уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Нийслэлийн цагдаагийн удирдах газраас 2022 онд иргэдээс цагдаагийн алба хаагчдад холбогдуулан гаргасан гомдол мэдээлэл, сахилгын мэдээнд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Эерэг хандлага-Хуульч ажиллагаа-2023” нөлөөллийн аяныг хэрэгжүүлэн ажилласнаар энэ оны эхний хагас жилд 127 сахилга, ёс зүйн зөрчилд 151 алба хаагч холбогдсон нь өмнөх оны мөн үеэс сахилга, ёс зүйн зөрчил 39 нэгжээр буюу 23.4 хувиар, алба хаагч 38 нэгж буюу 20.1 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Дөрөв. Албаны сургалт, хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, байнгын хороо, Төрийн албаны зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулиас зохион байгуулсан 3 хэлэлцүүлэг, 2 сургалт, 1 уулзалтад давхардсан тоогоор 7 алба хаагч хамрагдаж, санал дэвшүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 35 дугаар захирамжаар байгуулагдсан “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем”-ийг хөгжүүлж, холбогдох бусад системтэй уялдуулан нэвтрүүлэх арга хэмжээ авах “Ажлын хэсэг”-ийн гишүүдийг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч уулзан, санал солилцох ажлыг зохион байгууллаа.

“Хүний нөөцийн ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд энэ оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 20 алба хаагч илтгэл ирүүлсэнээс 8 илтгэлийг 2 дугаар шатанд шалгаруулж, хэлэлцүүлэн, тэргүүлсэн 3 алба хаагчид батламж гардуулж

урамшуулсан.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж 82 алба хаагчийг хамруулсан.

Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих зорилгоор Төрийн албанаас цахимаар зохион байгуулсан 30 удаагийн 60 цагийн сургалтад цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хүний нөөцийн ажилтнуудыг хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө"-ний дагуу албаны 3618 удаагийн сургалтад давхардсан тоогоор 535.559 алба хаагчийг хамруулан үр дүнг тооцож ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн үргэлжилсэн сургалтын төлөвлөгөөний дагуу Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдыг ажлын байрнаас хөндийрүүлэхгүй бие даан судлах боломжийг бүрдүүлэн 12 төрлийн 41 хичээл сургалтыг Цагдаагийн ерөнхий газрын цахим сургалтын нэгдсэн системд нээлттэй байрлуулан 9525 алба хаагч хамрагдсан. Албаны сургалтад хамрагдан 9526 алба хаагчаас 21-40 цагийг 1800 алба хаагч, 41-60 цагийг 5458 алба хаагч, 61-80 цагийг 2268 алба хаагч хангасан байна.

Нийт зохион байгуулагдсан 3618 сургалтын 2146 буюу 59.3 хувь нь лекц танхимын сургалт, 624 буюу 17.2 хувь нь дадлага сургууллт, 848 буюу 23.5 хувь нь зайн болон цахим сургалтаар зохион байгуулагдсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг алба хаагчийн ур чадвар, зөв дадал, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн чадамжид суурилсан сургалтыг явуулах үндсэн зарчмуудыг удирдлага болгон Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас хяналтад авч хэрэгжилтийг тайлагнах бодлогын баримт бичгийн жагсаалттай уялдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны А/46 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцоход 93.1 хувь буюу 4,6 оноотой, албаны сургалтын төлөвлөгөө 95.2 хувь буюу 4,7 оноотой тус тус дүгнэгдсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх албаны болон давтан мэргэшүүлэх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, "Цахим сургалтын нэгдсэн платформ"-ыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн нь орон зай, цаг хугацаа, төсөв хөрөнгийг хэмнэсэн төдийгүй байгууллага, алба хаагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр алба хаагчийг бие даан судлах нөхцөл боломжийг бүрдүүлсэн ач холбогдолтой байна.

Цагдаагийн алба хаагчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, алба хаагчийн өөрөө сурч, хөгжих хандлагыг төлөвшүүлэх, эрмэлзлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө"-ний дагуу 815 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 701 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 3112 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 38.693.800 төгрөг зарцуулсан.

Зохион байгуулсан зарим онцлог сургалтаас дурдвал:

“Гөү смарт ” ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан “Хугацаагүй лицензтэй сургалтын платформ, аппликейшн хэрэглэх тухай” НЦГ/202305011 тоот гэрээний дагуу “Динамик” цахим сургалтын платформыг энэ оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сургалтад нэвтрүүлж алба хаагчдыг ажлын байрнаас хөндийрүүлэхгүй бие даан судлах боломжийг бүрдүүлэн 12 төрлийн 41 хичээл сургалтыг нээлттэй байрлуулсан 9525 алба хаагч хамрагдсан. Мөн төлөвлөгөөт бус 51 төрлийн сургалт, тэмцээн, шалгалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 60926 алба хаагчийг хамруулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны А/224, А/102 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэх хангах журам”, мөн сайдын 2018 оны А/57 дугаар тушаалаар баталсан “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техник, хэрэглэх заавар”, мөн оны А/88 дугаар тушаалаар баталсан “Дотоодын цэргийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”-ын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх чиглэлээр сурган дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтыг Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагын хэмжээнд энэ оны 03 дугаар сарын 06-30-ны өдрийн хооронд 3 ээлжээр батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулж, явцын шалгалт авч, үр дүнг тооцон ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит удирдамжийн дагуу нийт бие бүрэлдэхүүнээс бие бялдрын түвшин тогтоох үзлэг зохион байгуулж, 47 анги байгууллагын 6611 алба хаагч үзлэгт хамрагдаж, 80 ба түүнээс дээш үнэлэгдсэн 4301, 80-аас доош үнэлэгдсэн 1059, хамрагдаагүй /ээлжийн амралт, албан томилолт, өвчтэй, чөлөөтэй/ 1251 алба хаагч байна.

Мөн алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байгаа “цагдаагийн хурандаа”, “хурандаа” цолтой 151 удирдах ажилтан, орон нутгийн цагдаагийн газрын 9 удирдах ажилтан нийт 160 алба хаагчдаас бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгийг Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо “Монгол-Солонгос” дурсгалын цэцэрлэгт хүрээлэнд 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын чуулган”-ыг угтан хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Гадаадын их, дээд сургууль төгссөн залуу офицеруудын нэгдсэн уулзалт”-ыг энэ оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж, танхимаар болон цахимаар 98 алба хаагч хамрагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эмэгтэй офицеруудын манлайлах, мэргэжлээрээ бахархах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, албандаа хандах хандлага, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, урам зоригийг сэргээх, нийгмийн идэвхийг өрнүүлэх, тэдний гэр бүл, хөгжлийг дэмжихэд чиглэсэн олон талт ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эмэгтэй залуу офицеруудын нэгдсэн уулзалт”-ыг энэ оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, уулзалтад цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 410 эмэгтэй

алба хаагч танхим болон цахимаар хамрагдсан.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын их дээд сургуулиудтай хамтран ажиллаж, цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ III, V жилийн хөтөлбөрийн сургалтад 259, магистрын хөтөлбөрийн сургалтад 53, докторын хөтөлбөрийн сургалтад 9, Удирдлагын академийн өдрийн хөтөлбөрт 7, ОХУ, АНУ, БНИУ, БНТУ, БНСУ, БНУУ, Австрали улс зэрэг 7 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 93, нийт 421 алба хаагчийг суралцуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагыг бэхжүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах, бүс нутаг, олон улсад үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах зорилгоор гадаад улсад Англи хэлний сургалтад хамруулах сонгон шалгаруулалтад 183 алба хаагч өрсөлдөж, онооны дарааллаар 107 алба хаагч шалгарч, эдгээр алба хаагчдыг Бүгд Найрамдах Филиппин Улсад 60/41 гэсэн хоёр ээлжээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.

Алба хаагчдын үйл ажиллагааг мэргэшүүлэх, сурган зааварчлах зорилгоор сургагч багш бэлтгэх 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 281 алба хаагчийг сургагч багшаар бэлтгэсэн. Үүнд:

“Цагдаа”, “Харуулчин”, “Цагдаа жолооч”, “Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх”, “Гэрээт харуул хамгаалалтыг ажилтан бэлтгэх” сургалтуудад хичээл заах сургагч багш нарын “Заах арга зүйн” сургалт, “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”-ын дагуу “Сургагч багш бэлтгэх” сургалт, мөн “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, бэлтгэх, хангах журам”-ын сургалтын сургагч багшийн давтан сургалт, “Үндэсний бичиг”-ийн сургагч багш бэлтгэх, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний эрхийн “Сургагч багш”-ийн давтан сургалт, “Хүч” спорт хороо, Тусгай ажиллагааны газартай хамтран бие бялдрын хөгжил, дасгал хөдөлгөөний “Сургагч багш” бэлтгэх сургалт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах чиглэлээр бэлтгэгдсэн сургагч багшийн давтан сургалт зэрэг болно.

Сургагч багш нарын ажлыг “Маш сайн”, “Сайн”, “Дунд”, “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлсэн бөгөөд “Маш сайн”-7, “Сайн”-37, “Дунд”-21, “Хангалтгүй”-13 алба хаагч дүгнэгдсэн.

Тав. Албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах ажлын хүрээнд

Дотоодын цэргийн штаб, Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Санхүү, ар талын алба, Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс, Урьдчилан сэргийлэх газар, Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлуулж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудаас бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах талаар ирүүлсэн 134 санал, материал хүлээн авч, холбогдох ажиллагааг хийн, Цагдаагийн ерөнхий газрын даргын 52 тушаалаар 84 асуудлыг шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Хуулийн хэлтсийн бүтцэд “Алба хаагч, ажилтны эрхийг хамгаалах тасаг”-ийг байгуулсан.

Алба хаагчдын цалингийн зэрэглэлийг нэмэгдүүлэх талаар энэ онд 2 удаа судалгаа гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу энэ оны

7 дугаар сард 12117 алба хаагчийн цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлуулж, 11 дүгээр сард Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны А/340 дүгээр тушаалаар 9841 алба хаагчийн цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх шийдвэр гаргуулсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас “Түрээслээд өмчлөх орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 25 алба хаагчдад батламж гардуулах ажиллагааг зохион байгуулсан.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Төрийн албан тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгосон 358 алба хаагч, ажилтанд нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж 18,736,2 сая төгрөг, Цагдаагийн албаны тухай хуулийн 89.2 дахь заалт “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил”-ыг 138 алба хаагчдад 3,006,9 сая төгрөг олгосон.

Мөн ажил үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан 8 алба хаагчийн ар гэрт 36 сарын цалин хөлстэй тэнцэх 379,7 сая төгрөг, 3 алба хаагийн ар гэрт 60 сарын цалин хөлстэй тэнцэх 237,8 сая төгрөгийн тэтгэмж, ажил үүргээ гүйцэтгэж байгаад бэртсэн 4 алба хаагчдад хөдөлмөр хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлсэн нөхөн олговор 124,2 сая төгрөг тус тус олгосон байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/18 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг боловсруулж, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Мөнх даатгал” ХХК-тай 88,723,200.00 төгрөгөөр, Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Хаан даатгал” ХХК-тай 117,270,770.00 төгрөгөөр тус тус гэрээ байгуулан, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

Даатгалын байгууллагатай байгуулж байгаа гэрээнд алба хаагч, ажилтны эрхийг хамгаалах, эрх зүйн байдлыг дээшлүүлэх чиглэлээр цагдаагийн алба хаагч Уралдаан тэмцээн, жагсаалын бэлтгэл, дасгал сургуулилтын үед бэртэж гэмтэх болон цус харвалт, Жагсаал, цуглаан албаны бэлэн байдалд ажиллах үеийн бүх төрлийн эрсдэл, Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн ажилтан ажлын болон ажлын бус цагаар бэртэж гэмтэх, эрсдэлд орох талаар тусган хэрэгжүүлж байна. Энэ онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 188 үйлдэлд 206 алба хаагч өртөж, хохирсон тохиолдол бүртгэгдсэнээс даатгалын байгууллагаас “Гэнэтийн ослын даатгалын гэрээ”-ний дагуу нөхөн төлбөр гаргуулахаар 10 алба хаагчийн материалыг хүргүүлж, мөрдөн шалгах ажиллагааны явцад 37 алба хаагчид учирсан 23.7 сая төгрөгийн хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлжээ.

2023 онд он дамжсан 7, шинээр баригдсан 1 барилгад захилалагчийн хяналт хэрэгжүүлж ажлласан. Үүнээс Өвөрхангай аймгийн Богд, Хужирт, Баянхонгор аймгийн Богд, Жаргалант сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын цагдаагийн хэлтэс, тасгийн барилгыг Улсын комисст хүлээлгэн өгч, бүрэн ашиглалтад оруулсан. Одоо он дамжих нийт 3 барилгаас Архангайн аймгийн барилга 70%, Хэнтий аймгийн Батноров сумын барилга 50%, Баян-овоо сумын барилга 30%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зургаа.Төрийн албаны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд

Цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим хуудаст

цагдаагийн байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг байршуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар 412 мэдээг нийтэлж, нийт 412.816 удаагийн хандалттай байна. Цахим хуудсанд байршуулж нийтэлсэн нээлттэй мэдээллийг шинэчлэх бүрд шинээр веб холбоос оноож, өмнөх хувилбарыг архивлаж, хандах боломжийг бүрдүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага 35 цахим хуудас, 57 facebook хуудсаар гэмт хэрэг, зөрчлийн талаар 2045, урьдчилан сэргийлэх чиглэлээр 10214, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавьяаг алдаршуулах чиглэлээр 3854, бусад 2204 мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээсэн.

Нээлттэй мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд, бусад мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол хяналт тавин ажиллаа.

Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв” /11-11/, И-мэйл: complaints@police.gov.mn, цагдаагийн алба хаагчтай холбоотой гомдол мэдээлэл авах 126 тусгай дугаарын утас, цагдаагийн байгууллагын алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдийн дугаарыг тус тус www.police.gov.mn цахим хуудаст байршуулсан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Засгийн газрын энэ оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийн хүрээнд “Нийтийн мэдээллийн ил тод байдал”-ын тухай хуулийн 23.3-т “иргэний бүртгэлийн дугаараар хүнд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаараар хуулийн этгээдэд цахим шуудангийн хаягийг хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр мэдэгдэл хүргэх системд үүсгэнэ” гэж заасны дагуу E-Mongolia платформ дээр суурилсан “Үндэсний цахим шуудан”-гаар дамжуулан иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, санал хүсэлтийг цахим хаягаар хүлээн авч байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д заасны дагуу цагдаагийн байгууллагын сул орон тоог цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдаас сонгон шалгаруулж, нөхөн хангах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны Б/03 дугаар тогтоолоор 1275, алба хаагчийн 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан ахлагчаас офицер албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэсэн 179, нийт 1454 алба хаагчийн нэрийг дэвшүүлэх нөөцийн жагсаалтад оруулан баталж, цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Гарын авлага” цэсэнд байршуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор зохион байгуулсан сонгон шалгаруулалтын мэдээ, сул орон тооны мэдээллийг 7 удаа Цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим сайт болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын цахим сайтад байршуулж, 70191043, 70191095 дугаарын утсаар иргэдийн тодруулсан асуултад хариулан ажилласан.

Дээрх зарыг Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 35 цахим сайт, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын албан ёсны фэйсбүүк /page/-д 210 удаа нийтэлсэн нийтлэлийг 3.976.821 хүн үзэж, 10382 хүнд таалагдаж байгаагаа илэрхийлж, 1023 хүн сэтгэгдэл үлдээсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/80 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ыг шинэчлэн батлуулж, цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим хаягийн “Хууль, эрх зүй” цэсний “ЦЕГ-ын даргын

тушаал” дэд цэс, цагдаагийн байгууллагын мэдээллийн системийн “Хууль, эрх зүйн акт” хэсгийн “ЦЕГ-ын даргын тушаал” хэсэгт тус тус байршуулсан.

Шилэн дансны нэгдсэн системд 2023 оны төсвийн батлагдсан хуваарийг 1 дүгээр сарын 15-ны дотор, 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг 1 дүгээр сарын 08-ны өдөр, 2024 оны төсвийн төслийг 9 дүгээр сарын 10-ны дотор хуульд заасан хугацаанд нийтэлсэн.

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 11 мэдээллийг шилэн дансны цахим систем www.shilendans.gov.mn-нд хуулийн хугацаанд нь байршуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/319, энэ оны А/67, А/231 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан урсгал зардлаас санхүүжих нийт 49 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд болон өдөр тутмын сонин буюу “Өглөөний сонин” хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, мөн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаарх мэдээллийг www.shilendans.gov.mn цахим системд тухай бүрд оруулан олон нийтэд ил тод нийтэлсэн

Долоо. Маргаан хянан шалгах ажлын хүрээнд

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04/792 дугаартай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/348 дугаар тушаалыг эс зөвшөөрч иргэн Д.Алтангадасаас гаргасан гомдолтой танилцаад хариу тайлбар, баримтын хамт 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/206 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04/1258 дугаартай “иргэн М.Лхагвасүрэнгээс гаргасан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний Б/536 дугаар тушаалаар албанаас халж, цагдаагийн цол хураасан шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдол”-ын тухай албан бичигтэй танилцаад 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/353 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хариу тайлбар, нотлох баримтын хамт хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04/2099 дугаартай “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Б/982, 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Б/1042 дугаар тушаалыг эс зөвшөөрч иргэн Д.Бат-Оргил, Б.Мөнх-Оргил нарын гаргасан гомдолд тайлбар ирүүлэх тухай” албан бичигтэй танилцаад 2023 оны 09 дүгээр сарын 29-ний 01/521 дугаартай албан бичгээр тайлбар, баримтыг хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04/2387 дугаартай “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/1188 дугаар тушаалыг эс зөвшөөрсөн тухай” албан бичигтэй танилцаж, холбогдох баримт, тайлбарыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/323 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04/2396 дугаартай “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Б/1085 дугаар тушаалыг эс зөвшөөрсөн тухай” албан бичигтэй танилцаж, холбогдох баримт, тайлбарыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/324 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02/2527 дугаартай “Баримт ирүүлэх тухай” албан бичигтэй танилцаад холбогдох 47 хуудас баримтыг хүний нөөцийн

хэлтэс, Төв архив, Санхүү, ар талын албанаас авч, 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2/342 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Баримт, тайлбар ирүүлэх тухай” 04/2715 дугаар албан бичигтэй танилцаад цагдаагийн ахлах ахлагч Л.Болортуяагийн албаны шалгалтын болон бусад холбогдох материалыг мөн сарын 22-ны өдөр 03/391 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн “Ганмягмарын Болор-Эрдэнэтэй холбоотой материал ирүүлэх тухай” албан бичигтэй танилцаад Ганмягмарын Болор-Эрдэнийн хувийн хэргийг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 56/7846 дугаартай албан бичгээр Дотоод хэргийн их сургуулийн мэдэлд шилжүүлсэн тухай албан бичгийг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/781 дугаартай албан бичгээр тус зөвлөлд хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газарт болон бусад этгээдэд холбогдуулан 2023 онд эрүүгийн хэрэгт иргэний хариуцагч, иргэн, захиргааны хэрэгт хариуцагч, нэхэмжлэгчээр нийт 32 хэрэгт Хуулийн хэлтсээс итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаагаас нийт 16 хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж, одоо үлдэгдэл 16 хэрэг ажиллагаанд байгаагаас анхан шатанд 10, давж заалдах шатанд 3, хяналтын шатанд 3 хэрэг байна.

Засгийн газрыг төлөөлөн Хуулийн хэлтсээс итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, 2023 оны байдлаар 19 иргэний хэрэгт оролцож, 10 хэргийг эцэслэн шийдвэрлүүлж, одоо 9 хэрэг ажиллагаанд байгаагаас анхан шатанд 7, давж заалдах 2 хэрэг, хяналтын шатанд хэрэг байхгүй байна. Засгийн газарт холбогдох 10 хэргийг 100 хувь Засгийн газрын талд гаргаж, шийдвэрлүүлж байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 32 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 104 удаа оролцож, 15 хэрэг буюу 93.3 хувь байгууллагын талд эцэслэн шийдвэрлэгдэж, 1 хэрэг нэхэмжлэгчийн талд шийдвэрлэгдсэн.

Нийт 137.738.300 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгуулж, байгууллагын талд шийдвэр гаргуулсан.

Найм. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь энэ онд төсөвт 10963, гэрээт 1154, нийт 12117 алба хаагч /офицер 6121, ахлагч 5475, энгийн 511, нөөцөд 10/-ийн батлагдсан орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Үүнээс өнөөдрийн байдлаар 11022 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 995 орон тоо /офицер 530, ахлагч 382, энгийн 83/ сул байна. /Офицер - алба, нэгж 141, нийслэл 187, аймаг 145, ДЦ-54, ахлагч-алба, нэгж 124, нийслэл 156, аймаг 72, ДЦ-53/

Харьяа алба, нэгж, байгууллагаас ирүүлсэн хүний нөөцийн томилолттой холбоотой хүсэлтүүдийг хүлээн авч удирдлагад төслөөр танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1595, Дотоодын цэргийн командлагчийн 120, Захиргааны удирдлагын газрын даргын 124, нийт 1839 тушаалаар 9855 алба хаагчийн хүний нөөцийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Тайлант хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас нийт 1205 /чөлөөлөгдсөн 954, халагдсан 146/ алба хаагч, ажилтан дараах үндэслэлээр албанаас халагдаж, чөлөөлөгдсөн. Үүнд:

- Албанаас халагдсан /ЦАТХ 81.4.5, 82.1.1, 2, ТАТХ 47, 48.1.3, 48.1.4/- 146
- өөрийн хүсэлтээрээ албанаас чөлөөлөгдсөн 488,

- цэргийн алба хаасны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор ажлаас чөлөөлсөн 240,
- хүүхэд асрах чөлөө олгон ажлаас чөлөөлсөн 109,
- цагдаагийн байгууллагын захиалгаар суралцуулахаар 23,
- эрүүл мэндийн шалтгаанаар 2,
- бусад үндэслэлээр 8,
- данс бүртгэлээс хассан /нас барсан/ 13,
- Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 заасны дагуу бусад төрийн байгууллагад шилжүүлж ажиллуулсан 60,
- Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-д заасны дагуу бусад төрийн байгууллагад сэлгэн ажиллуулсан 11 алба хаагч,
- хөдөлмөрийн гэрээ цуцалж /энгийн/ 105 ажилтан байна.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт болон халагдаж, чөлөөлөгдсөнөөс үүссэн сул орон тоог нөхөн хангах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, “Төрийн жинхэнэ албаны нөөц”-д бүртгэгдсэн 1006, Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дугаар зүйлийн 139.2 дахь заалтыг баримтлан хүүхэд асрах чөлөө цуцалсан хүсэлт гаргасан 77, сургалтын чөлөө цуцалсан 7, Дотоод хэргийн их сургууль төгссөн 184, Орос, Турк, Солонгос улсын цагдаагийн академи төгссөн 21, болон Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасныг баримтлан 57 алба хаагч, ажилтныг шилжүүлэн авч, нийт 1353 орон тоог нөхсөн.

Мөн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албан тушаал дэвшүүлэх 2020-2023 оны нөөцөд бүртгэгдсэн 813 алба хаагчийг дэвшүүлэн, дотоодын нэгж хооронд 755 алба хаагчийг шилжүүлэн томилсон.

Тайлант онд 1205 алба хаагч халагдаж, чөлөөлөгдсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 550 буюу 31.3 хувиар, 1596 алба хаагч шилжилт хөдөлгөөн хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 398 буюу 33.2 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Төрийн одон, медаль Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар алба хаагч, ажилтан, ахмад ажилтныг шагнуулахаар нэр дэвшүүлснээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Гавьяат хуульч”-р 1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-р 3, “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-р 5, “Цэргийн гавьяаны одон”-р 40, “Алтангадас” одонгоор 3, “Цэргийн хүндэт медаль”-р 179, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-р 11, “Шударга журам” медалиар 2, нийт 244 алба хаагчийг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “Хууль зүйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 64, “Цагдаагийн алдар” хүндэт тэмдгээр 148, “Хүндэт жуух бичиг”-р 224, нийт 436 алба хаагч, ажилтан, ахмад ажилтан шагнагдсан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар “Цагдаагийн байгууллагын хүндэт ажилтан тэмдэг”-р 6, “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 120, “Хүндэт жуух”-аар 513, “Спортын алдар” тэмдгээр 13, “Дотоодын цэргийн алдар” тэмдгээр 32, “Эрүүгийн цагдаагийн хүндэт ажилтан тэмдэг”-р 5, “Цагдаагийн төлөө” тэмдгээр 2, “Цагдаагийн албаны төлөө I-III” медалиар 1040, нийт 1731 алба хаагч, ажилтан, ахмад ажилтныг шагнаж урамшууллаа.

Энэ хугацаанд 1411 алба хаагч, ахмад ажилтнуудыг шагнаж шийдвэрлүүлсэн нь нийт алба хаагчдын 21.8 хувийг эзэлж байна

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цэргийн алба хаасны тэтгэвэр

тогтоолгохоор 2023 онд ажлаас чөлөөлөгдсөн 240 ахмад ажилтаныг “Монгол цагдаа” медалиар шагнаж, урамшуулсан.

Харьяа нэгж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулиас цагдаа, дотоодын цэргийн цол олгуулахаар ирүүлсэн материалыг хүлээн авч 1732 алба хаагчид холбогдох журмын дагуу цол олгосон.

Үүнд: Цагдаагийн 1536, Дотоодын цэргийн 49, Дотоод хэргийн их сургуулийн 46, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 56, Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албаны 43, Хил хамгаалах ерөнхий газрын 2 алба хаагч байна.

Ес. Дүгнэлт

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл нь:

-Салбар зөвлөлийн ажлын төлөвлөлт, тайлагналт, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалт, шийдвэрийн албажуулалт, түүний хэрэгжилтэд тавих хяналт, албан хэрэг хөтлөлтийн стандарт, архивын бүрдүүлэлт буюу салбар зөвлөлийн дотоод ажил шаардлагын түвшинд явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор Төрийн тусгай албан тушаалын ангилал шинэчлэн баталсны дүнд цалин нэмэгдсэн нь алба хаагчид тогтвор, суурьшилтай ажиллах бололцоог бүрдүүлж байна.

Алба хаагчдын тогтвор, суурьшилтай ажиллах бололцоог бүрдүүлэн цалингийн өрсөлдөх чадвар дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны “Цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх тухай” А/340 дүгээр тушаалаар энэ оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс цагдаа, дотоодын цэргийн байгууллагын зарим алба хаагчдын цалингийн зэрэглэлийг 1-2 шатлалаар нэмэгдүүлсэн.

Цалинд өөрчлөлт орсон 9841 алба хаагчийн 7.6 хувь нь удирдах, 92.4 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан байгаа ба 1 алба хаагчийн цалин дунджаар 103.700-198.000 төгрөгөөр нэмэгдсэн байна. Дээрх тушаалд нийт алба хаагчдын 90.4 хувь хамрагдсан.

-Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах ажлыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, баяжилтыг тухай бүр хувийн хэрэгт хийн ажиллаж байна.

Тайлант онд 1205 алба хаагч халагдаж, чөлөөлөгдсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 550 буюу 31.3 хувиар, 1596 алба хаагч шилжилт хөдөлгөөн хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 398 буюу 33.2 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

-Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн, хугацаатай албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд нь хүргүүлж ажилласнаар 2023 онд төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлсэн гэж дүгнэж байна.

Арав. Санал

- Цагдаагийн алба хаагчийн мэргэшсэн байдал, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлийг Цагдаагийн ерөнхий газрын цахим сургалтын платформоор алба хаагчдад нээлттэй судлуулж, албаны сургалтын үр дүнг сургалтын кредит цагийг хангасан байхыг шалгуур болгож үнэлэх;

-Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд алба хаагчдын харилцааны хууль эрх зүйн болон мөрдөн шалгах ажиллагааны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг оновчтой, үр дүнд хүрэхүйц хэлбэрээр төлөвлөн зохион байгуулах;

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоос хамаарч Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д Төрийн тусгай байгууллагын албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27.1.4-т заасан нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгууллагын онцлогоос хамаарч мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах саналтай байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ